



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 499

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Ардчилсан нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Хэрлэн сумын Ардчилсан нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Хэрлэн сумын Ардчилсан нам"-ын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: /Аймгийн/ Сонгуулийн хороонд
Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛОРТУУЛ

011020517



ШИНЭ ХЭРЛЭН



АЙМАГ, НИЙСЛЭЛ, ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Орон нутгийн хөгжил, ард иргэдийн эрх ашиг, ардчиллын үнэт зүйлээ эрхэмлэн, Ардчилсан намынхаа 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн “Монгол өрх 2020”, аймгийн Ардчилсан намын “Шинэ Дорнод” мөрийн хөтөлбөрүүд болон хувь хүний эрх чөлөө, хуулийн хариуцлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд тулгуурлан тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд,

Баатар хотын минь хүн бүр нь хүсэл мөрөөдөлтэй, өрх айл бүр нь аз жаргалтай амьдрах, хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй эрх тэгш хариуцлагатай байж, ХЭРЛЭН сумаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Иргэдийнхээ эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, баялаг бүтээгчдийн таатай орчин
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан

Дорнод аймгийн Хэрлэн сумын ардчилсан нам 2020-2024 оны орон нутгийн сонгуульд оролцож өрх гэрүүдийн амьдралын чанарыг бодитоор дээшлүүлэх үзэл санаанд тулгуурласан “Шинэ Хэрлэн” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

Нэг.Хүн төвтэй, шинэ ХЭРЛЭН

- Өрсөлдөх чадвартай боловсрол
- Чанартай эрүүл мэндийн үйлчилгээ
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал
- Соёл, урлаг, спорт

Хоёр.Баялаг бүтээгч, шинэ ХЭРЛЭН

- Үйлдвэржилт
- Бизнесийн таатай орчин
- Дэд бүтэц, хот төлөвлөлт
- Хөдөө аж ахуй, газар тариалан

Гурав. Эзэнтэй, шинэ ХЭРЛЭН

- Сум, багийн хөгжлийн тэнцвэр
- Хариуцлагатай засаглал

- Нээлттэй, иргэний хяналт

Дөрөв. Алсаа харсан, шинэ ХЭРЛЭН

- Ногоон хот
- Гадаад хамтын ажиллагаа
- Иргэний хамгаалал

НЭГ. ХҮН ТӨВТЭЙ ШИНЭ ХЭРЛЭН

1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол



Сумын нийт хүн амын боловсрол, эрүүл мэндэд анхаарч, одоо хэрэгжиж байгаа сайн хөтөлбөр, үйл ажиллагааг үргэлжлүүлэн, шинээр хүн амын хөгжилд шат ахих орон нутгийн онцлог хэрэгцээнд суурилсан хөтөлбөр, ажлуудыг идэвхтэй санаачлан хэрэгжүүлнэ.

Ингэхдээ хувь хүний хөгжлийг ямагт өмнөө тавьж, нийгмийн халамж, хамгааллын талаар авах арга хэмжээг жинхэнэ зорилтот бүлэгт чиглүүлэхэд манлайлан ажиллана.

- 1.1.1 Цэцэрлэг сургуулийн анги дүүргэлтийг одоо байгаа түвшнээс бууруулна.
- 1.1.2 Хөрш зэргэлдээ 2 орны их дээд сургуульд залуусыг суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 1.1.3 Мэргэжлийн боловсрол сургалт үйлдвэрлэлийн төвд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд анхаарч ажиллана.
- 1.1.4 Ерөнхий боловсролын салбарын улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 1.1.5 Багш бэлтгэдэг их дээд сургуулийн чадавхыг бэхжүүлж багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлэх боломжийг дэмжиж ажиллана.
- 1.1.6 Тусгай хэрэгцээт иргэдтэй ажиллах мэргэжилтэнг албан байгууллагуудад бий болгож дохионы хэлний сургалтад хамруулж чадваржуулна.
- 1.1.7 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртэй итгэлтэй, орон нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлаараар бахархдаг хүмүүжил олгох "Зөв Хүүхэд" хөтөлбөрийг сэргээн сайжруулж, үргэлжлүүлнэ.
- 1.1.8 Ардчилал, хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг иргэн бүрд төлөвшүүлэх зорилгоор "Зориг"-ын өдөр бий болгоно.

- 1.1.9 Дорнод их сургуулиа түшиглэн багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургаж хөгжүүлэх зорилгоор “Шинэ багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.10 Дорнод их сургуулийн статусыг нэмэгдүүлж олон улсын чанартай их сургуулийн хөтөлбөрт нийцүүлэн хөгжүүлнэ.
- 1.1.11 Насан туршийн боловсролын төвийг Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран иргэний боловсролыг дээшлүүлэх чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлнэ.

1.2 Чанартай эрүүл мэндийн үйлчилгээ

- 1.2.1 Жилд 1 удаа ХХҮГ, НДХ, БОЭТ, ӨЭМТ, ААН, багийн ажлын албатай хамтран хувийн хэвшлийн болон ажилгүй иргэдийг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах боломжийг бүрдүүлж ажиллана.
- 1.2.2 ӨЭМТ-үүдийн тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ.
- 1.2.3 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн Эрэгтэйчүүдийн тасаг шинээр байгуулна.
- 1.2.4 Хэрлэн сумын багийн байршил, хүн амын нягтралыг харгалзан өрхийн эмнэлэг нэмж байгуулна.
- 1.2.5 ӨЭМТ-ийг түшиглэн гэрийн эмчийн тэтгэвэрт гарсан, дадлага туршлагатай эмч нарын мэдээллийн бааз бүрдүүлэн “Гэрийн эмч”-ээр ажиллуулах боломжийг бүрдүүлж ажиллана.
- 1.2.6 Хорт хавдрыг эрт илрүүлэх чиглэлд анхаарч ажиллана.
- 1.2.7 Бэлгийн замын болон халдварт өвчний тандалт, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулах бодлого баримтална.
- 1.2.8 Чийрэгжүүлэх төвүүдийг дэмжиж, хуулиар олгосон боломжид тулгуурлан хөнгөлөлт үзүүлж ажиллана.

1.3 Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал

- 1.3.1 Ахмадын өдөр өнжүүлэх төвүүдийг бий болгоно.
- 1.3.2 Нийгмийн халамжийн чиглэлээр сайн дурын ажлыг дэмжих урамшуулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.3.3 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн дэмжлэгийг халамж шаардлагатай өрх иргэдэд хүргэнэ.
- 1.3.4 Сургууль, цэцэрлэг дотуур байр, спорт заал, хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандартыг мөрдүүлнэ. Барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам, шат бүхий хэрэгсэл суулгана.
- 1.3.5 Нийгмийн эрүүл мэндийг халдварт өвчин, хүрээлэн буй орчны бохирдлоос үүсэж болзошгүй тахлын аюулаас урьдчилан сэргийлнэ.

1.4. Соёл урлаг, спорт

- 1.4.1 Соёл, урлагийн салбарыг мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлнэ.
- 1.4.2 Аймгийн Музей дэх Чойбалсан хотын түүхтэй холбоотой үзмэрүүдийн баяжуулалтыг нэмэгдүүлнэ.
- 1.4.3 ОХУ, БНХАУ-ын хил залгаа хот, мужтай хамтран хүүхэд залуучуудын дунд урлаг, спортын бэлтгэл сургуулилалт, арга хэмжээ, олон улсын тэмцээн зохион байгуулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.4.4 “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.5 Усан бассейн байгуулах хөрөнгө оруулалтын ажлыг дэмжинэ.


ХОЁР. БАЯЛАГ БҮТЭЭГЧ ХЭРЛЭН

2.1. Үйлдвэржилт

- 2.1.1. Хоёр хөрштэйгээ жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллаж экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- 2.1.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг орон нутгийн бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.3. Барилгын материалын үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, хуулийн хүрээнд таатай нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллана.
- 2.1.4. Хөнгөн үйлдвэрийн кластрын системийг нэвтрүүлж Дорнодын брэнд бүтээгдэхүүнийг улс, олон улсын зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.5. Уул уурхайн салбарын олборлосон түүхий эдийг баяжуулж экспортлох бодлого хэрэгжүүлж баяжуулах үйлдвэрүүдийг дэмжинэ.
- 2.1.6. Адуунчулууны нүүрсний ордыг түшиглэн өрхийн, аж үйлдвэрийн хэрэгцээнд нүүрс шигших, ялгах бага оврын үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

2.2. Бизнесийн таатай орчин

- 2.2.1. Олон улсын гаалийн баталгаат агуулахын талаарх бизнесийг дэмжинэ.
- 2.2.2. Байгалийн дурсгалт газрыг түшиглэн Эко системд нөлөөлөхгүй аялал жуулчлалын бааз байгуулахыг дэмжинэ.
- 2.2.3. Орлого багатай өрхийн ажилгүй хөдөлмөрийн насны гишүүнийг мэргэжлийн болон мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулан орлогын эх үүсвэртэй болгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана.
- 2.2.4. Жижиг бизнес эрхлэгчдийг бизнес инкубатор төвөөр дамжуулан бойжуулж тогтворжуулж зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж ажиллана.
- 2.2.5. Орон нутгийн бизнес, зах зээлийн орчны давуу талд тулгуурлан шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх шинэ санаа, шилдэг санаачлагыг бодлогоор дэмжиж ажиллана.



2.3. Дэд бүтэц, хот төлөвлөлт

- 2.3.1. Монгол Өрх 2020, Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын хүрээнд зүүн бүсийн тулгуур төвийн төлөвлөлтөд нийцүүлэн Хэрлэн сум, Чойбалсан хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.
- 2.3.2. Дорнод НАА ОНӨГ ус цэвэршүүлэх төхөөрөмжид шинэчэл хийнэ.
- 2.3.3. Хэрлэн сумын хуучны орон сууцны босоо шугамыг шинэчилнэ.
- 2.3.4. Гэр хорооллын дундах замыг хатуу хучилттай болгох ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.3.5. 6-р багийн Ивээл хорооллыг дахин төлөвлөлтөд оруулж шинэ орон сууцны хороолол байгуулна.
- 2.3.6. Орон сууцны байруудын засвар үйлчилгээ хийх, тохижилтын "Орон сууц хөгжлийн сан"-г бий болгоно.
- 2.3.7. Хэрлэн голын гадаргын болон үерийн усыг нөөцлөх санг байгуулж, өрхийн газар тариаланд ашиглах ажлыг эхлүүлнэ.
- 2.3.8. Чойбалсан хотын цэвэр, бохир усны болон дулааны шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх/ Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр/ шийднэ.
- 2.3.9. Хэрлэн голын бүс дагуу ил спорт талбай бүхий тохижилтыг нэмэгдүүлнэ.
- 2.3.10. Чойбалсан хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. Иргэдийн болон аж ахуй нэгжийн оролцоотой тохижилтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3.11. Чойбалсан хотын авто зам болон явган зорчигч, дугуйт зорчигчийн замын ухаалаг төлөвлөлтийг нэвтрүүлж замын нэгдсэн сүлжээг бүрэн шинэчилнэ.
- 2.3.12. Цэцэрлэгт гудамжийн тоог нэмэгдүүлж гэр хорооллын бүсэд нийтийн амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- 2.3.13. Чойбалсан хотын гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулахад онцгой анхаарч ажиллана. "Жорлонгоо шинэчилье" хөтөлбөрийг сурталчлан, иргэдийн оролцоотой нүхэн жорлонгийн тоог бууруулна.

2.4. Хөдөө аж ахуй, газар тариалан

- 2.4.1. Чойбалсан хот болон сум суурин орчмын үржил шимт газруудад хүнсний ногоо тариалах талбайг иргэдэд түрээсээр эзэмшүүлж хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжиж ажлын байр бий болгоно.
- 2.4.2. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортод гаргах боломжийг өргөтгөнө.
- 2.4.3. Малын эрүүл мэнд, үржлийн асуудлаар Бүс нутгийн хэмжээнд үйлчилгээ үзүүлэхүйц хамтарсан аж ахуйнуудыг дэмжинэ
- 2.4.4. Цөм сүргийн бүтцүүдийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулна.
- 2.4.5. Малын бүртгэлийн олон улсын системийг нэвтрүүлнэ.
- 2.4.6. Мал аж ахуйн судалгаа, шинжилгээ, инновац, технологийн олон улсын болон бүсийн төвүүдийг байгуулна.
- 2.4.7. Мал аж ахуй, газар тариалан хосолсон бүлгийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 2.4.8. Эрүүл, аюулгүй органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 2.4.9. Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд байгальд ээлтэй орчин үеийн усалгаат тариалан \дуслын систем\ эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ГУРАВ. ЭЗЭНТЭЙ, ШИНЭ ХЭРЛЭН

3.1. Сум, багийн хөгжлийн тэнцвэр

- 3.1.1. Зүүн бүсийн тулгуур төвийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3.1.2. Иргэдийн оролцоотой болон концесс, төсвийн дэмжлэгтэйгээр “Шинэ баг” төсөл хэрэгжүүлнэ.
- 3.1.3. Гэр хорооллын ундны цэвэр ус, худгийн цахим ажиллагааг тасралтгүй үйл ажиллагаагаар хангахад хяналт тавина.
- 3.1.4. 1, 2, дугаар багийн Ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төвийг иргэдэд ойртуулна.
- 3.1.5. Алслагдсан 1, 2, 3, 5, 8 дугаар багуудад хувийн хэвшлийн сектортой хамтран ахуйн үйлчилгээний төв байгуулна.
- 3.1.6. 4, 10 дугаар багийн шинэ эгнээг эрчим хүч, гүний худгаар хангана.
- 3.1.7. Гэр хорооллын хог хаягдлыг үе шаттайгаар цэвэрлэх, устгах, дахин боловсруулах чиглэлээр холбогдох төрийн байгууллага, ААН-тэй хамтран хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж ажиллана.

3.2. Хариуцлагатай засаглал

- 3.2.1. Төрийн алба болон үйлчилгээний албанд ажиллагсдын ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлж, хяналттай хариуцлагатай засаглалыг төлөвшүүлнэ.
- 3.2.2. Төрийн болон төрийн үйлчилгээний албанд ажиллагсдын ур чадварыг бодитоор дээшлүүлэхэд онцгой анхаарна. Давтан сургах, дадлагажуулах ажлыг тасралтгүй сургалцах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Төрийн үйлчилгээний “Нэг цонхны үйлчилгээ”-г иргэдэд хүртээмжтэй болгох үүднээс тоог нэмэгдүүлэхэд анхаарна.
- 3.2.4. Сумын хэмжээнд нийт хурал, уулзалтыг 50 хувь цахим хэлбэрээр хийх бодлого барьж ажиллана.
- 3.2.5. Хуулийг бүх шатанд чанд мөрдүүлж, ил тод, авлигаас ангид хариуцлагатай засаглалыг хэрэгжүүлэхэд Иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн оролцоотойгоор хяналт тавьж ажиллана.
- 3.2.6. Хэрлэн гол дагасан салхины урсгал дагуу цахилгаан хэрэглээ ихтэй Ай ти сервер роом байгуулж мэдээллийн технологийн старт апп-уудыг богино хугацааны үр дүн харахгүйгээр дэмжинэ.

3.3. Нээлттэй, иргэний хяналт

- 3.3.1. Төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалт, санхүүгийн тайланг иргэдэд ил тод болгоно.
- 3.3.2. Аливаа лиценз, зөвшөөрөл олгох үйл явцыг хуульд нийцүүлэн шуурхай, хүртээмжтэй болгож бүрэн шинэчлэн зохион байгуулна.
- 3.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтыг иргэдэд нээлттэй болгож “Шилэн данс”-ны хуулийг мөрдүүлэн ажиллана.

- 3.3.4. Татвар төлөгчдийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж тайланг "Иргэний танхим"-аар нээлттэй хэлэлцүүлж, санал дүгнэлтийг тусган ажиллана.
- 3.3.5. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ил тод байлгаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулан, гарсан шийдвэрийг тухай бүрд нь олон нийтийн сүлжээнд байршуулж, цахим засаглалыг хэрэгжүүлнэ.
- 3.3.6. Сумын Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд туршлагатай, салбар салбарын төлөөллийг оролцуулсан "Бодлогын зөвлөл" байгуулан ажиллуулна.

2117144066
ЖЮА0056 9030891

ДӨРӨВ. АЛСАА ХАРСАН, ШИНЭ ХЭРЛЭН

4.1. Ногоон хот

- 4.1.1. Гэр хорооллын өрх, айлуудын дунд "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж, ногоон байгууламж бий болгох ажлыг дэмжинэ.
- 4.1.2. 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах элс, хайрга олборлолт явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээр нөхөн сэргээлт хийлгэж, хяналт тавьж, хуулийн хариуцлага хүлээлгэдэг байдлыг мөрдүүлнэ.
- 4.1.3. Байгууллага, аж ахуйн нэгж бүрийг стандартад нийцсэн ногоон байгууламжтай болгох арга замыг нэвтрүүлж ажиллана.
- 4.1.4. Чойбалсан хотын хот тохижилтын байгууллагын материаллаг баазыг сайжруулж, шинэ технологи нэвтрүүлэх замаар эко орчин бүрдүүлнэ.
- 4.1.5. Чойбалсан хотыг орчин үеийн Ногоон хот болгоход чиглэсэн аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн аливаа санал санаачлага, төсөл хөтөлбөр, оролцоог бүх талаар дэмжиж ажиллана.

4.2. Гадаад хамтын ажиллагаа

- 4.2.1 "Орос, Хятадын нэг бүс-нэг зам" төсөлд идэвхтэй, санаачлагатай оролцох чиглэлээр бие даасан санаачлага хөтөлбөр дэвшүүлж гурван талт хамтын ажиллагаа, олон улсын хөгжлийн интеграцид нэгдэж ажиллана.
- 4.2.2 Сумын хөгжлийн бодлогын чиглэлээр ажиллаж байгаа бүрэлдэхүүнийг 100 хувь гадаад хэлтэй, чадварлаг боловсон хүчнээр бүрдүүлж ажиллана.
- 4.2.3 Чойбалсан хотыг Зүүн хойд Азийн аялал жуулчлал, бизнес худалдааны чөлөөт бүс болгоно.

4.3 Иргэний хамгаалал

- 4.3.1. Болзошгүй тал, хээрийн болон ахуйн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 4.3.2. Иргэний хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдэд мэдлэг олгоно.
- 4.3.3. Сургууль бүрийг "сургуулийн автобус"-тай болгоно.

- 3.1.1. Аюулгүй амар тайван орчныг бүрдүүлэхэд Чойбалсан хотыг бүрэн хэмжээнд хяналтын камерын системтэй болгож нэгдсэн удирдлагатай болгоно.
- 3.1.2. Залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх төвүүдийг улсын төсөв, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтад тулгуурлан байгуулах ажлыг дэмжинэ.
- 3.1.3. Байгууллагуудад ХАБЭА-н стандартыг нэвтрүүлнэ.

